

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/02.

Арвайхээр сум

Г Хуваарь, чиг үүрэг шинэчлэн батлах тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 -ийг үндэслэн  
ТУШААХ нь:

1.Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээг эрсдэлгүй, шуурхай хүргэх үүднээс байгууллагуудыг Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдэд хариуцуулж, ажиллах хуваарийг нэгдүгээр, ажиллах ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хуваарийн дагуу хариуцсан эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг холбогдох эмч, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны "Хуваарь, чиг үүрэг батлах тухай" а/45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Н.ОЮУНТУЯА



622001011

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
01 дүгээр сарын 21-ны өдрийн 40 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ЗООНОЗ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ТӨВ, ХАРХОРИН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ЭМГ-ЫН  
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХУВААРЬ

д/д	Албан тушаал	Хариуцан ажиллах нэгж байгууллага
1	Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг
2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
3	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	Богд сумын эрүүл мэндийн төв
4	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга	Уянга сумын эрүүл мэндийн төв, Жаргалан багийн эмнэлэг
5	Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламж, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Есөнзүйл сумын эрүүл мэндийн төв
6	Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	Бат-Өлзий сумын эрүүл мэндийн төв
7	Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Баруунбаян-Улаан сумын эрүүл мэндийн төв
8	ЗСНҮА-ны дарга, Ахлах нягтлан бодогч	Бүрд сумын эрүүл мэндийн төв
9	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Сант сумын эрүүл мэндийн төв
10	Статистик мэдээллийн ажилтан	Баянгол сумын эрүүл мэндийн төв
11	Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан	Нарийнтээл сумын эрүүл мэндийн төв, Баянтээг багийн эмнэлэг
12	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Зүүнбаян-Улаан сумын эрүүл мэндийн төв
13	Орчны эрүүл мэнд, ариутгал халдваргүйтгэл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Өлзийт сумын эрүүл мэндийн төв
14	Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, ахмад настны эрүүл мэнд, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв
15	Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Тарагт сумын эрүүл мэндийн төв

16	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Төгрөг сумын эрүүл мэндийн төв
17	Эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн	Хайрхандулаан сумын эрүүл мэндийн төв
18	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Гучин-Ус сумын эрүүл мэндийн төв
19	Халдварт өвчин, бэлгийн зам, эмнэлгээс шалтгаалах, цусаар дамжих болон гэдэсний халдварын тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	Хужирт сумын эрүүл мэндийн төв
20	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Зооноз өвчин судлалын төв
21	Хүүхдийн тусламж үйлчилгээ, магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төв
22	Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан	Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төв
23	Халдварт өвчин, амьсгалын замын халдвар, сүрьеэ, зоонозын халдварын асуудал хариуцсан мэргэжилтэн	Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төв
24	Халдварт бус өвчин, нийтийн биеийн тамир, архи, тамхины хэрэглээг бууруулах, хүн амын зохистой хооллолтын асуудал хариуцсан мэргэжилтэн	Энэрэл хархорин өрхийн эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
01 дүгээр сарын 21-ны өдрийн 40 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ЗООНОЗ  
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ, ХАРХОРИН СУМЫН НЭГДСЭН  
ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙГ  
ХАРИУЦСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

**Дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

1. Эрүүл мэндийн газар болон бусад байгууллагаас хүргүүлсэн хариутай бичиг болон мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь ирүүлэх чиг үүрэг өгч ажиллах;

2. Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарсан яаралтай зар, мэдээллийг утсаар шуурхай хүргэж, байгууллагын удирдлага, холбогдох хэлтэс албанд эргэн мэдээлэх;

3. Эрүүл мэндийн салбараас гарч буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал, шийдвэр, тухайлсан жил, онцлох үйл ажиллагаа, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;

4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж буй стандарт, удирдамж, зааврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амын ялангуяа эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар холбогдох зөвлөмжөөр хангаж, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг холбогдох албан тушаалуудад танилцуулж шийдвэрлүүлэх;

6. Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр тулгамдаж буй асуудлыг тухай бүр цаг алдалгүй удирдлагуудад танилцуулах;

7. БОЭТ болон төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлгүүдэд ажлын байранд сэлгүүлэн ажиллуулах, дагалдан сургалтад бүрэн хамруулах;

8. Эрүүл мэндийн газар болон бусад байгууллагаас зарласан цахим болон танхимын сургалтад холбогдох эмч, мэргэжилтнийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах;

9. Хариуцсан сумын тулгамдаж буй асуудлыг улирал бүр тодорхойлж, холбогдох чиглэлийн дагуу мэргэжлийн баг бүрдүүлж, ажлын байранд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажиллах;

9.1. Мэргэжлийн багийн ажиллах хугацааны ажлын хөлс, урамшууллыг шалгуур гарган баталгаажуулж, тухайн сум, өрх хариуцан олгоно.

9.2. Тухайн баг жилд 1-2 удаа, 2-3 хоног ажлын байранд ажиллаж, тулгамдсан асуудлын дагуу мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллана.

10. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн, хэрэгжилтэд хамтран ажиллах;

11. Хариуцсан эрүүл мэндийн байгууллагыг БОЭТ-ийн мэргэжлийн багуудтай холбох ажлыг зохион байгуулах;